



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/69

Хэрлэн сум

Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт Монгол Улсын Хилийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журмын 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн зөвлөгөөнийг Чингис хотод 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, 1,200,000 (нэг сая хоёр зуун мянган) төгрөгийн зардлыг зарцуулсугай.

2.Зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөвлөгөөний хөтөлбөрийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Батлагдсан журмын дагуу хилийн сумдад Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөл байгуулан, хилийн салбаруудтай нягт хамтран ажиллахыг Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д даалгасугай

5.Аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, хилийн сумдын Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлд захирамжийг хүргэн үүрэг даалгавраар хангаж, мэргэжлийн удирдлага арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Зөвлөлийн орлогч дарга, Хилийн цэргийн 0287 дугаар ангийн Захирагч (хурандаа П.Мөнхбаатар), Зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





۵۵/۳

حکمہ
پسم و
۲۵
پسم لکھ
۲۵
پسم

[illegible][illegible][illegible][illegible][illegible][illegible]

46. یکم صفر

فہرست مضامین:



ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ ЗӨВЛӨГӨӨНД
ОРОЛЦОХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС

1. Д.Аюурбунь Хэнтий аймгийн Засаг дарга бөгөөд Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн дарга,
2. П.Мөнхбаатар ХХТХ-ний зөвлөлийн орлогч дарга, Хилийн цэргийн 0287 дугаар ангийн захирагч, хурандаа
3. А.Жаргалсайхан ХХТХ-ний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
4. Б.Цогт-Орших ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
5. Ч.Баярцолмон ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Хууль, эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
6. Н.Үнэнбат ХХТХ3-ийн гишүүн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
7. Б.Түмэнжаргал ХХТХ3-ийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон
8. Л.Цэнддорж ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Цэргийн штабын дарга, дэд хурандаа
9. М.Шаравгаваа ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
10. Г.Болормаа ХХТХ3-ийн гишүүн, Давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч
11. Б.Ганзориг ХХТХ3-ийн гишүүн, Прокурорын газрын ерөнхий прокурор, Хууль цаазын шадар зөвлөх
12. О.Баярлхагва ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Тагнуулын ерөнхий газрын Хэнтий аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа
13. Э.Жавхлантөгс ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Цагдаагийн газрын дарга, хурандаа
14. Ж.Эрдэнэбат ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Онцгой байдлын газрын дарга, хурандаа
15. Д.Хатанбаатар ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нээлттэй 419 дүгээр ангийн захирагч, хурандаа

16.Б.Энхболор	ХХТХЗ-ийн гишүүн, Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
17.Г.Билгээ	ХХТХ-ний зөвлөлийн гишүүн, Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
18.Х.Мөнхжаргал	ХХТХЗ-ийн гишүүн, Хэнтий аймаг дахь Цахилгаан холбооны газрын дарга
19.Б.Амгаланбат	ХХТХЗ-ийн гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
18.С.Мөнхцэцэг	ХХТХЗ-ийн гишүүн, Боловсролын газрын дарга
19.Г.Гантөмөр	ХХТХЗ-ийн гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
20.О.Од-Эрдэнэ	ХХТХЗ-ийн гишүүн, Мэдээлэл, холбоо, сүлжээний газрын дарга
21.Ш.Мөнххуяг	ХХТХЗ-ийн гишүүн, Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлийн дарга, Дадал сумын Засаг дарга
22.Ц.Дэмбэрэлсайхан	ХХТХЗ-ийн гишүүн, ХХТХСЗ-ийн дарга, Биндэр сумын Засаг дарга
23.Б.Алтангэрэл	ХХТХЗ-ийн гишүүн, ХХТХСЗ-ийн дарга, Батширээт сумын Засаг дарга
24.Р.Энхтөр	ХХТХЗ-ийн гишүүн, ХХТХСЗ-ийн дарга, Өмнөдэлгэр сумын Засаг дарга

Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 07-ний өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР

д/д	Зохион байгуулах ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Зөвлөгөөн зохион байгуулагдах танхимыг бэлтгэх	14.00-14.30	Хууль, эрх зүйн хэлтэс
2	Зөвлөгөөнийг нээж үг хэлэх	14.30-14.40	ХХТХЗ-ийн дарга, Хэнтий аймгийн Засаг дарга Д.Аюурбунь
3	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах болон зөвлөлийн ажиллах журмыг танилцуулах,	14.40-15.00	ХХТХЗ-ийн нарийн бичгийн дарга, Засаг даргын тамгын газрын дарга А.Жаргалсайхан
4	ХХТХЗ-өөс, аймгийн байгууллага, газар, хэлтсийг хилийн салбаруудтай шифийн харилцаа тогтоох хуваарь танилцуулах		
5	Ангийн товч танилцуулга, ХХТХЗ-ийн 2021-2024 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланг танилцуулах	15.00-15.20	Хилийн 0287 дугаар ангийн захирагч, Хурандаа П.Мөнхбаатар
6	ХХТХЗ-ийн гишүүдээс 2021-2024 оны ажлын гүйцэтгэлтэй холбоотой саналыг сонсох	15.20-15.40	ХХТХЗ-ийн гишүүд
7	ХХТХЗ-өөс 2025 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг танилцуулах	15.40-15.50	Хилийн 0287 дугаар ангийн захирагч, Хурандаа П.Мөнхбаатар
8	Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталгаажуулах	15.50-16.10	Хилийн 0287 дугаар ангийн захирагч, Хурандаа П.Мөнхбаатар ХХТХЗ-ийн гишүүд
9	ХХТХЗ-ийн хурлыг хааж үг хэлэх	16.10-16.20	ХХТХЗ-ийн дарга, Хэнтий аймгийн Засаг дарга Д.Аюурбунь
10	ХХТХЗ-ийн зөвлөгөөнд оролцогчид дурсгалын зураг татуулах	16.20-16.30	Хууль, эрх зүйн хэлтэс